

“ГЕРМЕС ЦЕНТР” ХК-ИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үйл ажиллагааны талаар:

Манай компани нь эхний хагас жилд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. Компанийн нийт ажиллагсадтай 2020 онд хөдөлмөрийн гэрээгээ шинэчлэн байгуулж, ажиллагсдын ажлыг “Ажилтны үнэлгээний хуудас”-аар улирал тутамд дүгнэж байна.
2. Компанийн ажиллагсад сар тутам хурал хийж, мэдээ мэдээллийг танилцуулан, харилцан зөвшилцөх зарчмаар ажлаа явуулж байна. Коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс ажилтан ажиллагсдаа нэг удаагийн маск, нэг удаагийн малгай, бээлий зэрэг хамгаалах хэрэгслээр бүрэн ханган ажиллалаа.
3. Худалдааны төвийн нийт түрээслэгчидтэй түрээсийн гэрээгээ шинэчилж байгуулсан. Түрээслэгчдийг даатгалд бүрэн хамруулсан болно.
4. Түрээслэгчдэд сар бүр тогтмол захидал хүргүүлж байна. Түрээслэгчдийн зүгээс тавьсан санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ирлээ. Түрээслэгч нарт сар бүр хүргүүлж байгаа албан захидлаар коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өдөр тутам амны маск хэрэглэх, гараа сайтар савандаж угаах, гар дээрээс халуун хоол унд болон бусад бараа бүтээгдэхүүнийг худалдан авахгүй байх, ажлын байран дээр хооллохгүй байх, урин дулаан цаг ирсэнтэй холбогдуулан ажлын байран дээр хүүхэд багачуудаа дагуулж ирэхгүй байх, өөрсдийн биеийн дархлаагаа сайжруулах амин дэм хэрэглэх, нус цэр шүлс тамхины ишээ ил задгай хаяхгүй байх, олон нийтийн сүлжээгээр гарч байгаа буруу ташаа мэдээлэлд автахгүй байх, бусдад худал мэдээлэл тарааж, айдас хүйдэст автуулахгүй байхыг захиргааны зүгээс байнга анхааруулан зөвлөж байна.
5. Коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор худалдааны төвд 2 удаа халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн компаниар хийлгүүлсэн. Үүнээс хойш бид өөрсдөө халдваргүйжүүлэгч аппарат, ариутгалын бодисыг худалдан авч, худалдааны төвд долоо хоногт 3 удаа халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж байна.
6. БГД-ийн Онцгой байдлын хэлтсээс 2020 оны галын аюулгүй ажиллагааны дүгнэлтийг гаргуулан авсан. Мөн худалдааны төвийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, дүүргийн Онцгой байдлын хэлтсээр хянуулан баталгаажуулсан.
7. Аливаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянгол дүүргийн цагдаатай хамтран ажиллаж байна. Хорооны цагдаа хулгай, залилан, гэмт халдлагаас урьдчилан сэргийлж ажиллах талаар манай худалдааны төвийн түрээслэгчдэд зөвлөмж өгч заншлаа.
8. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг УОКомиссын шийдвэрийн дагуу онлайн хэлбэрээр утсаар болон вайбэр ашиглан 2020 оны 3-р сарын 20-ны өдөр хуралдуулсан бөгөөд хурлын материалыг холбогдох журмын дагуу СЗХороо, МХБиржид тус тус хүргүүлсэн.
9. Компанийн вэб сайтыг шинэчилж, холбогдох хууль, журмын дагуу мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулж байна.
10. Худалдааны төвийн барилга, байшин, зам талбай, хашаанд өдөр тутмын урсгал засварын ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэж байна.
11. Татварын байгууллагад төлөх ёстой татвараа хугацаанд нь төлж ирлээ.

Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:

1. “Гермес Центр” ХКомпанийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүдийг танилцуулахад нийт хөрөнгө 8 630.1 сая төгрөг. Үүнээс:

- Эргэлтийн хөрөнгө 2 183.3 сая төгрөг
- Эргэлтийн бус хөрөнгө 6 446.8 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 8 384.5 сая төгрөг
- Тайлант үеийн цэвэр ашиг 530.2 сая төгрөг байна.

2. Татварын өр төлбөрийн тухай :

Манай компани нь 2020 оны эхний хагас жил улсад 179.3 сая төгрөгийн татварыг төлөөд байна. Үүнд:

- ААН-ийн ОАТатварт 25.3 сая төгрөг,
- Ажиллагсдын цалингаас суутгасан хувь хүний ОАТатварт 6.5 сая төгрөг,
- НДШимтгэлд 18.8 сая төгрөг,
- НӨАТатварт 66.5 сая,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 24.1 сая төгрөг,
- Газрын татварт 5.9 сая төгрөг
- Ногдол ашгийн татварт 32.2 сая төгрөг

3. Орлогын үр дүнгийн тухай :

Манай компани 2020 оны эхний хагас жилд 772.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, хадгаламжийн хүүний 196.5 сая төгрөгийн орлоготой ажиллалаа. Нийт орлогын хэмжээ 968.6 сая төгрөг байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллаж байна.

4. Зардлын тухай :

Тус компани нь 2020 оны эхний хагас жилд 379.6 сая төгрөгийн зардалтай ажилласан. Зардлыг төлөвлөгөөнөөс хэтрүүлээгүй болно.

5. Ашгийн тухай

Компани 2020 оны эхний хагас жилд 530.2 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа.

6. Ногдол ашгийн тухай

Тус компанийн 2020 оны эхний хагас жилд нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ 6 төгрөг 75 мөнгө байна. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн төлөвлөгөө 6 төгрөг 54 мөнгө байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 103%-тай гарсан. Компанийн хэмжээнд эхний хагас жилийн орлого, зарлагын төлөвлөгөөг биелүүлэн ажиллалаа.

Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:

“Гермес Центр” ХКомпани нь 2020 оны 02-р сарын 18-ны бүртгэлийн өдрөөр 961 хувьцаа эзэмшигчидтэй байсан бөгөөд үүнээс:

- 28 хувьцаа эзэмшигчид нь аж ахуйн нэгж, байгууллага байгаа бөгөөд тэдгээр нь 5 901 236 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 7.5 %-ийг,

- 933 хувьцаа эзэмшигчид нь иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 72 641 765 ширхэг хувьцааг эзэмшиж, нийт хувьцааны 92.5%-ийг тус тус эзэмшиж байна.

Мөн хувьцаа эзэмшигч 933 иргэдийн хувьд:

- 30 хувьцаа эзэмшигчид нь гадаадын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 2 845 298 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 3.9 %-ийг, 903 хувьцаа эзэмшигчид дотоодын иргэд байгаа бөгөөд тэдгээр нь 69 796 467 ширхэг хувьцаа эзэмшиж, нийт хувьцааны 96.1 %-ийг тус тус эзэмшиж байна.

Компанийн 4-өөс дээш багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх %
1	Иргэн Д.Зоригт	42 530 145	54.14
2	Иргэн Д.Оюунсүрэн	23 460 015	29.87
3	“Импера Монголиа”ХХК	3 777 571	4.81
4	Бусад	8 775 270	11.17
Нийт дүн		78 543 001	100

Хаяг, холбоо барих ажилтан

1. Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 25-р хороо, Нарны зам – 20, “Гермес центр” ХК-ийн төв оффисын байр болон барилгын материалын Гермес худалдааны төв
2. Вэб хаяг: www.hermescenter.mn
3. Холбогдох утас: 976 – 11 – 30 15 77
4. Холбоо барих албан тушаалтан:
 - Нягтлан бодогч О.Энхтуяа
 - Мэргэжилтэн Д.Эрдэнэсүрэн